



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

### Загвар батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө, Нийслэлийн удирдлага болон Газрын даргын цаг үеийн асуудлаар гаргасан шийдвэр өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг богино хугацаанд үр дүнтэй төлөвлөх, тогтмол хяналт мониторинг хийх, удирдлагыг мэдээллээр хангах зорилгоор байгууллагын сарын ажлын төлөвлөгөөний загварыг нэгдүгээр хавсралтаар, биелэлт тайлагнах загварыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан загварын дагуу төлөвлөгөөг сар тутам нэгтгэн боловсруулж, тайлагнаж ажиллахыг нийт хэлтсүүдэд үүрэг болгосугай.

3. Цаг үеийн ажлын төлөвлөгөө, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга (Э.Даваахатан)-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын 2021 оны А/34 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Э.ТӨМӨРДУЛАМ

1150500156